


# ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ

ТОВХИМОЛ

# 2

БҮХ ШАТНЫ ЗАСАГ ДАРГА БОЛОН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ГИШҮҮДИЙН ГАРЫН АВЛАГА



Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 оронд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж, Боловсрол, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн хүрээнд үйлажиллагаагаа явуулж байна.

©Хүүхдийг Ивээх Сан, 2016 он

Боловсруулсан: Б.Батхүү  
Хянан тохиолдуулсан: Х.Өлзийтунгалаг  
Гарын авлагын зургийг Г.Ганбаяр

Хүүхдийг Ивээх Сан  
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
I дүгээр хороо, Аризона төв, 4-р давхар

Шуудангийн хайрцаг:  
Төв шуудан, ш/х-1023, Улаанбаатар хот 13, Монгол Улс

Утас: +976-11-329365,  
+976-11-329371

Факс: (976-11) 329361

И-Мейл: [secretary@savethechildren.mn](mailto:secretary@savethechildren.mn)

Facebook: Save the Children in Mongolia

Twitter: Save the children MN

Вэб: [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

# БҮХ ШАТНЫ ЗАСАГ ДАРГА БОЛОН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН (ИТХ) ГИШҮҮДИЙН ГАРЫН АВЛАГА

## ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Бүх шатны Засаг дарга нарт өөрийн харьяа нутаг дэвсгэртээ хүүхэд хамгааллын хууль, тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх үүргийг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11, 17 дугаар зүйлээр олгосон.

- 17 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын үүрэг, оролцоо
  - 17.1 Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхдийн эрхийг хангах талаар дараах арга хэмжээ авна:
    - 17.1.1. тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийг тэргүүлэх;
    - 17.1.2. хүүхдийн эрхийг хангах арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;
    - 17.1.3. тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх үр дүнг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;
    - 17.1.4. хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ, сургалт, хүмүүжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийг дэмжих, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
    - 17.1.5. хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах, хүүхдийн зориулалтын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, зориулалтын дагуу ашиглуулах;
    - 17.1.6. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Хүүхдийн эрхийн тухай хуулиас...

Харин нутгийн өөрөө удирдах байгууллагад хүүхдийн эрхийг орон нутагтаа хэрхэн хангах тухай бодлогоо тодорхойлох, хүүхдийн эрхийг хангах хөтөлбөр үйл ажиллагааг санхүүжүүлэх бүрэн эрхийг олгосон.

- II дүгээр зүйл. Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх
  - II.1. Хүүхдийн эрхийг хангах талаар Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
    - II.1.1. хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн болон орон нутгийн бодлогыг тодорхойлох;
    - II.1.2. хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөв батлах;
    - II.1.3. хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжид хяналт тавих;
- Хүүхдийн эрхийн тухай хуулиас...

Хүүхэд хамгаалал нь Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын хүрээнд зохицуулагдаж байдаг. Бүх шатны Засаг дарга нар Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэхийг шаардах, хэрэгжүүлээгүй болон зөрчсөн нөхцөлд зөрчлийг зогсоох, хэрэгжүүлэхийг шаардах хуулийн болон төрийн захиргааны арга хэмжээний механизмыг ашиглах эрхийг хуулиар олгосон байдаг.

Хуулийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа нь таниулан сурталчлах, хэрэгжилтийг хангах чадавхи, орчинг бүрдүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтийн хяналт, үнэлгээ зэрэг өргөн хүрээг хамарна.

Хуулийн хэрэгжилтийг хангуулахад бүх шатны Засаг даргын тамгын газар, түүний агентлагуудын оролцоо чухал үүрэгтэй. Засаг дарга эдгээр байгууллагыг өдөр тутмын удирдлагаар хангах бөгөөд харьяа нутаг дэвсгэртээ хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй.



## **ХҮҮХДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮР ДҮНГ ХЯНАХ, МЭДЭЭЛЭХ**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиар хөгжлийн чиглэл, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, хариуцлага тооцох үүргийг бүх шатны Засаг дарга нарт олгосон.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлд Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийг тэргүүлэх, хүүхдийн эрхийг хангах арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээсэн. Ялангуяа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг хүлээхээр заасан.

*Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын харьяалах нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах бүрэн эрхийг олгосон.*

Урт, дунд болон нэг жилийн төлөвлөлтийг зөв хийх нь чухал. Дунд хугацааны төлөвлөлт гэж сонгуулийн үр дүнгээр ялсан намын бодлогыг хэрэгжүүлэх Засгийн газрын болон бүх шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр гэж ойлгож болох юм. Энэ хөтөлбөр нь урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд суурилсан, илүү хэрэгжүүлэх стратегийн зорилго, зорилт, төсвийг тусгасан байдаг. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн

шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна гэжээ. Нутгийн захиргааны байгууллага дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.



Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхдийн хөгжил, хамгааллын дараах асуудлыг тусгаж болно. Үүнд:

- Хүүхдийн эрхийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах;
- Хүүхдийн эрхийг хангахтай холбоотой үүсгэл санаачилгыг дэмжих;
- Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих;
- Эдгээр байгууллагын үйл ажиллагаа, барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавих;
- Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн эрхийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх;
- Хүүхдийг төрийн асрамжид авах;
- Төөрсөн, орон гэрээсээ дайжсан болон бусад шалтгаанаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулах;
- Хүүхдийн оролцоог хөхиүлэн дэмжих;
- Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;
- Хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтанг аргагүйгээр хангах.

Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж болно.

Үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахдаа хэрэгцээ тодорхойлох, зорилго, зорилтоо томъёолох, үйл ажиллагаагаа нарийвчлах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээ тогтоох, төсвөө тооцох гэсэн үе шатаар боловсруулна. Хөгжлийн бодлого боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, чадавхжуулах нь чухал.



Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн, Засаг даргын саналыг үндэслэн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахад Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн 21 дүгээр зүйлийг баримтална. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна.

Хүүхэд хамгааллын хуулиар ИТХ болон Засаг дарга нь хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зардлыг орон нутгийн төсөвт суулгаж, санхүүжүүлнэ гэж заасан.

- 23 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт
- 23.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ;
- 23.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- Хүүхэд хамгааллын тухай хуулиас...



## ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАХ

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна. Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Мөн 2016 оны 9 сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхлэх Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх асуудлууд орсон.

- 21 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт
- 21.1. Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина;
- 21.2. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл нь жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна;
- 21.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна;
- 21.4. Олон улсын төрөлжсөн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын талаар хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж болно;
- 21.5. Гадаад улсын байгууллага, хуулийн этгээд нь Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт, судалгаа хийхийг хориглоно;
- 21.6. Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага нь хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын нөхцөл байдал, тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын талаар жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд тайлагнана.
- 22 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хяналт, шинжилгээ, үнэлгээ
- 22.1. Хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээг үнэлэх зорилгоор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ:
- 22.1.1. орон нутаг, анхан шатны нэгжээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бүртгэл, судалгааг нэгтгэн дүгнэх;

- 22.1.2. хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдийн талаар бүртгэл, судалгааг цагдаагийн болон хууль сахиулах бусад байгууллагатай хамтран гаргаж, дүн шинжилгээ хийх;
- 22.1.3. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, түүний үр дүнг үнэлж, шалгах;
- 22.1.4. хүүхэд хамгаалалд төрийн байгууллагуудын оролцоог үнэлэх;
- 22.1.5. хүүхэд хамгааллын хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, сургалтын чанар, үр нөлөөг үнэлэх;
- 22.1.6. хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх;
- 22.1.7. хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас...

## **ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАХ**

Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хүүхдийн хөгжил, хамгааллын байгууллага, амралт чөлөөт цаг, спортын байгууллагууд тухайн шатны Засаг даргын удирдлагад дор үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагыг байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах бүрэн эрх нь Засаг даргад байдаг.

Орчин үед байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдсан, хамааралтай байх болсон. Иймд хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдуулан байгууллагыг өөрчлөн зохион байгуулах, шинэчлэх нь чухал. Орон нутгийн удирдлагын байгууллагуудын бүтэц зохион байгуулалт нь хөгжлийн бодлоготойгоо уялдсан, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэнэ. Энэ арга зүйг хөтөлбөрийн төсөвлөлтийн арга гэдэг.

Эдгээр байгууллагын үйл ажиллагаа, хүртээмж, чанарыг сайжруулах арга хэмжээ авах, зохион байгуулах асуудал ч хамаарч байна. Үйлчилгээний нэр төрлийг тодорхойлох, эдгээрийн стандарт, норм хэм хэмжээг тогтоохоос эхэлнэ. Үйлчилгээний нэр төрөл, норм, стандарт шинэчлэгдэхийн хамт ажилтан, албан хаагч нарыг чадавхижуулах асуудал тулгарна.

Хүүхдийн байгууллагын барилга, байгууламжуудын ихэнх нь ашиглалтын хугацаа дууссан, хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас засвар үйлчилгээ цаг хугацаандаа хийгдээгүй байдаг. Иймд жил бүр шаардлагатай арга хэмжээ авах үүргийг хуулиар хүлээнэ.



## ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудад Хүүхэд хамгаалал, эрсдэлд өртсөн хүүхдийг хамгаалах талаар олон тооны заалтууд үйлчилж байна.

Хүүхдийн хувьд гэр бүл нь хамгийн аюулгүй, амгалан, тайван орчин байх ёстой. Харамсалтай нь хүүхдийг хүмүүжүүлэх нэрийн дор зодох, шийтгэх, хүчирхийлэх явдал байсаар байна.


Хүүхдийн эрхийн тухай хуульд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэр бүлдээ хүүхэд аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх, хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх, хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах үүрэгтэйг заасан.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17-р зүйлд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг Засаг даргад олгосон. Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар «эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд» гэдгийг эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд гэж тодорхойлсон.

Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээг хүүхэд хамгааллын хамтарсан багаар үзүүлэх, түүний үр дүнг үнэлж, шалгах, орон нутаг, анхан шатны нэгжээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бүртгэл, судалгааг гаргах, нэгтгэн дүгнэхээр заасан.

Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээг үзүүлнэ.

- Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх
- Аюулгүй байдлыг хангах
- Дэмжих, холбон зуучлах
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх
- Гэр бүлд нь эргэн нэгтгэх



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх, хууль хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих зэрэг заалтыг тусгасан байна.

Төрөөс эдгээр үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой нэмэлт зардлын хэмжээ, үйлчилгээний стандартыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд мөн бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаалахаар хуульчилсан. Хуулинд зааснаар дээрх нөхцөл үүссэн тохиолдолд Засаг дарга бүрэн эрхээ эдлэн хуулийг хэрэгжүүлэх ёстой. Харин хүүхдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах гэдэг ойлголтыг Дээд шүүхийн тайлбараар авч үзнэ.

Хүүхдийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэний санал хүсэлт, шүүхийн шийдвэрийг үндэслэн төрийн асрамжид авах шийдвэрийг тухайн шатны Засаг дарга гаргана. Энэ нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлд Засаг дарга нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн.

Эрсдлийн түвшинг нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан хамтран үнэлдэг бөгөөд эрсдлийн түвшингээс хамааран хүүхэд хамгааллын үйлчилгээг хамтарсан багаар, төлөвлөгөө гаргаж, үйлчилгээ үзүүлнэ. Эрсдлийн түвшинг үнэлэхдээ ХТҮГ-ын даргын 2016 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/42 тушаалаар батлагдсан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний маягт ХХ 03 буюу Хүүхдийн эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээний маягыг бөглөнө. Тус үнэлгээгээр эрсдлийн түвшин маш өндөр гэж гарвал шууд кейс нээн яаралтай үйлчилгээнд холбож, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлнэ. Харин эрсдлийн үнэлгээгээр эрсдэлтэй гэж гарвал хамтарсан багаар кейс нээж ажиллана.

*Хүүхэд хамгааллын талаар болон үйлчилгээний тухай илүү ихийг дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл А.Батхишиг, С.Энхтуяа нарын боловсруулсан Товхимол 1 болох “Хүүхэд хамгааллын хамтарсан баг” гарын авлагаас ерөнхий мэдээллийг авна уу.*

Хараа хяналтгүй, хаяг нь тодорхойгүй, гэр бүлдээ өсч хүмүүжих, суралцах боломжгүй, эрх нь зөрчигдөж байгаа болон хэрэг зөрчилд холбогдсон хүүхдийг түр саатуулах, халамжлах, хөдөлмөр хүмүүжлийн байгууллагад сурган хүмүүжүүлэх зардлыг төсвөөс санхүүжүүлнэ. Дээрх байгууллагыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусламжийн хөрөнгөнөөс санхүүжүүлж болно.

Хүүхдийг түр саатуулах, халамжлах болон хөдөлмөр, хүмүүжлийн байгууллагад зохих мэргэжлийн хүн ажиллах бөгөөд байр, танхим нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

Харьяа нутаг дэвсгэрт хүүхдийг аль болох гэр бүлийн орчинд өсгөн хүмүүжүүлэхийг зорино. Түүнээс өмнө Хүүхэд хамгааллын байр, төвүүд хүрэлцээгүй нөхцөлд төсвийн хөрөнгөөр болон бусад талуудын оролцоотой байгуулах арга хэмжээг авна.

*Мөн Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд хараа хяналтгүй хүүхдийг цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн нөхцөлд хүүхдийг хүлээн авсан байгууллага нь гурав хоногийн дотор харьяалагдах сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй. Мөн хүүхдийн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн хүүхдийн оршин суугаа /оршин байгаа/ газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй. Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхдийн амьдралын нөхцлийг судалж, эцэг, эх болон төрөл садангийн хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ.*

Сум, дүүргийн Засаг дарга нь эрсдэлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч асран халамжлах хүсэлт гаргасан иргэнд асран хамгаалалтыг шилжүүлж болно.

Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргаагүй, боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхдийг гэр бүлд түшиглэн асран халамжлах үйлчилгээнд хамруулах, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ. Хамгийн сүүлийн арга хэмжээ бол асрамж, халамжийн төв юм.

## ОЛОН НИЙТИЙН ҮҮСГЭЛ САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ

Орон нутгийн түвшинд хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд олон нийтийн санаачилга, оролцоог дэмжих нь ихээхэн чухал юм. Олон нийтийн санаачилга, оролцоог хангахын эрхзүйн болон бусад таатай нөхцөлийг бүрдүүлэх үүргийг Засаг дарга хүлээнэ. Үүнд:

- Хүүхдийн эрхийг хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, хүүхдийн оролцоог хөхиүлэн дэмжих, хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ.
- Хүүхэд, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөх, туслах үүрэгтэй нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжих, арга зүйн удирдлагаар хангана.
- Төөрсөн, орон гэрээсээ дайжсан болон бусад шалтгаанаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сургууль, цагдаагийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг оролцуулна.



## **ХОРОО, БАГИЙН ЗАСАГ ДАРГА**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлд бүх шатны Засаг дарга нь хүүхдийн эрхийг хангах арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх үр дүнг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлнэ гэж заасны хамт дараах үүргийг хороо, багийн Засаг даргад хүлээлгэсэн байдаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд ч энэ тухай зохицуулалт бий.

Засаг дарга нь хамтарсан багийн ахлагчийн хувьд багийн гишүүдийг хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх үүргийг хүлээсэн. Ялангуяа хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлтэй ажиллахад тодорхой орчин, орон зай, арга барил хэрэгтэй байдаг. Нийгмийн ажилтныг халамж, хөдөлмөрийн мэргэжилтний адил нэг цэгийн үйлчилгээний цонхонд суулгаж болохгүй юм.

Учир нь нийгмийн ажилтанд хандаж буй үйлчлүүлэгчийн асуудал нь олон хүний дэргэд ярьж болохгүй, нууцлалыг хамгаалах зайлшгүй шаардлагатай мэдээ, мэдээлэл байдаг. Үйлчлүүлэгчийн нууцлалыг хангах нь тухайн хүний амь нас, аюулгүй байдалтай холбоотой байхыг ч үгүйсгэх аргагүй.

## **ХАМТАРСАН БАГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДЛАГА, АРГА ЗҮЙ**

Засаг захиргааны анхан шатны нэгж сум, баг, хорооны түвшинд ажиллах хамтарсан багийн гишүүдийг аймаг, дүүргийн засаг дарга захирамжаар батална. Хамтарсан багийн гишүүдийг томилохдоо албан тушаалыг харгалзан батлана.

Хамтарсан багт байх бүтцийн хувьд хамтарсан багийн ахлагч нь тухай сум, хорооны Засаг дарга байна. Харин гишүүдийг томилохдоо тухайн орон нутгийн онцлог байдлыг харгалзан үзнэ. Жишээлбэл, Өвөрхангай аймгийн сумдад Хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд ажиллаж байгаа давуу талтай бол өөр аймаг, сумдад энэ бүтэц байхгүй байгаа. Энэ тохиолдолд Өвөрхангай аймгийн сумдад хамтарсан багийн кейс менежер нь хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нар болж байгаа юм. Ямар ч тохиолдолд кейс менежер нь эрхэлж буй ажил, үүргийн хуваарийн дагуу мэргэжлийн нийгмийн ажилтан байх ба хүүхэд хамгааллын үйлчилгээг чанартай, өндөр түвшинд хүргэнэ. Учир нь нийгмийн ажилтнаар 4 жил сурч, тус мэргэжлийн боловсролыг эзэмшдэг.

Хамтарсан багийг тухайн шатны Засаг дарга ахлах бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна. Хамтарсан баг нь өрхийн эмч, хороо, сум, сургуулийн болон халамжийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

Зарим орон нутагт Хүүхдийг Ивээх Сан, Дэлхийн зөн, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүүхэд хамгааллын ТББ-ууд үйл ажиллагаа явуулдаг бол харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтарсан багийн гишүүнээр ТББ-ын төлөөллийг батламжлан ажиллуулж болно.

Хамтарсан багийн нийтлэг, үндсэн бүтэц нь:

1. Засаг дарга - хамтарсан багийн ахлагч
2. Сум, хорооны нийгмийн ажилтан - багийн гишүүн, кейс менежер
3. Хорооны хэсгийн байцаагч - багийн гишүүн
4. Өрх, багийн эмч эсвэл эрүүл мэндийн нийгмийн ажилтан - багийн гишүүн
5. Хамран сургах тойргийн сургуулийн нийгмийн ажилтан - багийн гишүүн

Хүүхэд, гэр бүлд хамтарсан багаар үйлчилгээг үзүүлэх явцад хороо/баг/суманд ажиллаж буй мэргэжилтэн болон бусад ажилтны дэмжлэг, туслалцаа шаардлагатай тохиолдолд оролцуулна. Үүнд:

- а. Тухайн багийн засаг дарга
- б. Халамжийн мэргэжилтэн
- в. Хөдөлмөрийн мэргэжилтэн
- г. Тухайн нутаг дэвсгэрт хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл
- д. Тухайн хэсгийн ахлагч
- е. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хувьд орчуулагч, дохионы хэлний орчуулагч, хяналтандаа авсан эмч, сэтгэл зүйч, өмгөөлөгч гэх мэт
- ё. Хүүхдийн элч, олон нийтийн төлөөлөл гэх мэт

Хамтарсан баг нь нийгмийн бүх орчинд хүүхдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг цогц хэрэгжүүлнэ.

Хамтарсан багийн жилийн болон сарын ажлын төлөвлөгөөг тухайн харьяалах нутаг дэвсгэрт хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон тодорхой зорилго, зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагаа, хариуцах эзэн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт зэргийг тусган боловсруулж ажиллах нь оновчтой. Засаг дарга нь хамтарсан багийн ахлагчийн хувьд хамтарсан багийн ажиллах журам, жил, сарын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн хуралдааныг Засаг дарга, нийгмийн ажилтан шаардлагатай мэдээлэл, бүртгэлийг үндэслэн зарлан хуралдуулна. Засаг дарга нь хамтарсан багийн гишүүд болон хуулийн дагуу үүрэг хүлээгч талуудад хандан удирдамж, зөвлөмж өгнө. Хуралдаанаар батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт, төсвийг Засаг дарга, холбогдох байгууллагын удирдлагуудад танилцуулж хэрэгжүүлнэ.

#### **Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах тухай**

Хамтарсан багийн гишүүд ажил мэргэжлийн чиг үүргийн дагуу хуулиар хүний нууц, хүүхдийн нууцыг хадгалах үүргийг хүлээсэн.

Хамтарсан багт тухайн кейсийн онцлогоос шалтгаалан гишүүн бус хүнийг урьж оролцуулан дэмжлэг, туслалцаа авах тохиолдолд “Нууцыг хадгалах гэрээ”-г тухайн хүнтэй байгуулах бөгөөд хамтарсан багийн ахлагчийн хувьд Засаг дарга гэрээ байгуулагч талаас үзэглэнэ. Хамтарсан багийн ахлагчийн хувьд гишүүдэд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах талаар сануулж, мэдээллийн нууцыг задруулахгүй байхад анхаарч ажлаа төлөвлөж, хэрэгжүүлнэ.

## ЗАСАГ ДАРГЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ЧИГ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫН ХЭМ ХЭМЖЭЭГ ЗААСАН ЭРХ ЗҮЙ

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ нийгмийн чиглэлээр дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заажээ.

- нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; /нийтлэг 4 бүрэн эрх/
- харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах; /2 бүрэн эрх/
- хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагууд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих; /1 бүрэн эрх/
- нутаг дэвсгэрийнхээ хүн амын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг боловсруулж Хурлаар шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн зэрэг хууль тогтоомжид заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах ажлыг ерөнхий удирдлагаар хангах; /4 бүрэн эрх/

Хүүхдийн эрхийн тухай хуульд бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхдийн эрхийг хангах талаар дараах арга хэмжээ авна.

- тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийг тэргүүлэх;
- хүүхдийн эрхийг хангах арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;
- тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх, үр дүнг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;
- эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Хүүхдийн эрхийн тухай хуулинд Хүүхдийн эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт Хүүхдийн төлөө зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлэхээр заасан.





16.4. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

16.4.1. хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах;

16.4.2. хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх;

16.5. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үүргийг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тусын чиг үүргийн дагуу гүйцэтгэнэ.

Хүүхдийн эрхийн тухай хуулиас...

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлд сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүргийг хүлээсэн. Нийгмийн ажилтан бол хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа талаарх мэдээллийг хүлээн авч ажиллах, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн юм.

Тиймээс Засаг дарга нь нийгмийн ажилтны ажил үүргийн онцлогийг ойлгож, нөхцөл боломжоор нь хангаж өгөх нь тун чухал. Хамгийн наад зах нь нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл бүхий материалыг аюулгүй газар хадгалах, үйлчлүүлэгчтэйгээ уулзах өрөө нь ярилцлага хийх боломжтой, яриа нь сонсогдохгүй байх, үйлчлүүлэгчийнхээ яриаг бичиж авах дуу хураагуур байх гэх мэт мэргэжлийн онцлогийг нь ойлгож, дэмжин ажиллах шаардлагатай.

Төсвийн тухай хуулийн 61.1.6-д Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр заасан бөгөөд мөн хуулийн 61.2-д энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ гэж заажээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг тодорхойлсон.

- Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.
- Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж болно.
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн, Засаг даргын саналыг үндэслэн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахад энэ хуулийн 21 дүгээр зүйлийг баримтална.

- Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.
- Сум, дүүргийн түвшинд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлоготой байж болно.
- Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.
- Тухайн шатны ИТХ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засаг даргын бүрэн эрхэд үл хамаарах асуудал болон хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, үндэслэлгүй зорилт, арга хэмжээг тусгахыг хориглоно.
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг төсөв, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан, дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.
- Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ИТХ-д танилцуулж, тухайн жилийн 2 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг ИТХ зохион байгуулна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлд *Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлжээ.*

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна.
- Нутгийн захиргааны байгууллага дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.
- Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ИТХ-д танилцуулж, 2 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн хүүхдийн байгууллагын даргыг нийгмийн салбарын болон хүүхдийн байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж, томилно.

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах дараах хэм хэмжээг зохицуулж өгсөн байна.

- Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална.
- Энэ хуулийн 25.4, 25.5-д заасан хүүхдийн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн хүүхдийн оршин суугаа /оршин байгаа/ газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй.
- Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн хүүхдийг хүлээн авсан хүүхдийн буюу харгалзан дэмжих байгууллага нь гурав хоногийн дотор энэ тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй.
- Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 25.6, 25.7-д заасан хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхдийн амьдралын нөхцөлийг судалж, эцэг, эх болон төрөл садангийн хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ.
- Сум, дүүргийн Засаг дарга нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлж болно.
- Хүүхдийг энэ хуулийн 25.9-д заасны дагуу шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд бүх шатны Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна

- Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйчилгээний төв болон хамгаалах байр байгуулах асуудлаар санал боловсруулж, ИТХ-д мэдүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Орон нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, зардлыг тусгах талаар

санал, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөр, төсөл боловсруулж, ИТХ-аар батлуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

- Харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвлөж, ИТХ-д өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;
- Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах, салбар зөвлөл болон хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангах, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажилд хамт олон, хөрш, олон нийтийг татан оролцуулах, эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэн, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;
- Хуульд заасан бусад чиг үүрэг.

# БҮХ ШАТНЫ ИТХ-ЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙ

## **ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨХ, БАТЛАХ ҮЙЛ ЯВЦ**

ИТХ нь харьяалах нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогыг батлах, өөрчлөх, Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн тухайн нутаг дэвсгэрт нийтээр мөрдөх хэм хэмжээг тогтоох, төсөв батлах, хуваарилах, хянах үндсэн чиг үүргийг хүлээнэ.

Хүүхдийн хөгжил, хамгааллын хөгжлийн бодлогод дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны үндсэн чиглэл;
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан санаачилгыг дэмжих арга хэмжээ авах;
- Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- Засаг даргын явуулж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг болно.

Түүнчлэн хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр, стандартыг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөхөөр хуульчилж байдаг.

## **ХҮҮХДИЙН ХАМГААЛАЛ БОЛОН ХАМТАРСАН БАГИЙН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ**

*Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиудад Засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах бүрэн эрхийг олгосон байдаг.*

Хүүхэд хамгааллын бодлого, арга хэмжээний чухал хэсэг нь зардлыг зөв тодорхойлох, тооцох, хуваарилах, төсөвлөх, батлах явдал юм. Үүний зорилго нь:

- Бодлогын хүрээнд шаардлагатай тооцсон гарц, хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхийн тулд тухайн төсвийн жилд болон ойрын жилүүдийн шаардлагатай төсвийн нөөцийг зөв тодорхойлох;
- Урт, дунд, богино хугацаанд орон нутгийн удирдлагын хариуцлагыг төсвөөр дамжуулан баталгаажуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гадна хөтөлбөрийн үр өгөөжийг үнэлэх боломжийг бүрдүүлэхэд оршино.

Төсвийн зардлын тооцоог хийхдээ янз бүрийн зардлын ангилал, төрлийг тухайн хэрэгцээ, шаардлагаас хамааран ашиглаж байдаг. Гэхдээ эдгээр бүгд нийлж үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Зардлыг тогтмол ба хувьсах гэж ангилах нь нийтлэг байдаг. Тогтмол зардал гэж үйл ажиллагааны явцад жилийн туршид гарч буй өөрчлөлтүүд нөлөөлөхгүй байх зардлыг хэлнэ. Тогтмол зардалд барилга, үл хөдлөх хөрөнгө хамаарна.

Хувьсах зардал гэж үйл ажиллагааны явцад өөрчлөгдөж байх зардлыг хэлнэ. Хувьсах зардалд цалин, сэлбэг хэрэгсэл, бараа, үйлчилгээний зардал хамаарна. Хөтөлбөр, дэд хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад ажилтан нарын цалин, хөлс шууд зардлын гол бүрэлдэхүүн болж байдаг. Хөтөлбөрийн зардлыг тооцоход

шууд зардлаас гадна хөтөлбөрийн үйл ажиллагааг дэмжиж байгаа нэмэгдэл зардлуудыг зөв тооцох нь чухал. Хөтөлбөрийн зардлыг зөв тодорхойлохын тулд бүх зардлыг үнэн зөвөөр тодорхойлох ёстой. Тийм учраас нэмэгдэл зардлыг хөтөлбөрт зөв тусгах шаардлага гарч байдаг. Зардлын тооцоо нь төвөгтэй үйл явц бөгөөд зардлын төсөөллийг аль болох энгийнээр хийхийг хичээх ёстой. Нэмэгдэл зардлыг хөтөлбөрт тооцох тогтсон аргачлал байхгүй.

2l дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт

2l.3 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас

### **ИТХ-ЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ЧИГ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫН ХЭМ ХЭМЖЭЭГ ЗААСАН ЭРХ ЗҮЙ**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Тухайн шатны ИТХ нь Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлах, хэрэгжилтийг хянах.

Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар дараах арга хэмжээг авна.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд сум, дүүргийн Хурлын бүрэн эрхийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;
- засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах;
- орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн сан байгуулах, уг сангийн эх үүсвэр, зориулалтыг тогтоох, сангийн хөрөнгийн зарцуулалтын журам, тайланг батлах;

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг тодорхойлсон.

- Засаг дарга тухайн шатны ИТХ-аас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, ИТХ-аар батлуулна.



- Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж болно.
- Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг ИТХ-аар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.
- Тухайн шатны ИТХ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.
- Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ИТХ-д танилцуулж, 2 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг ИТХ зохион байгуулна.

16 дугаар зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлсон байдаг.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна.
- Нутгийн захиргааны байгууллага дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор ИТХ-д өргөн мэдүүлж, тухайн шатны ИТХ батална.
- ИТХ дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.
- Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ИТХ-д танилцуулж, 2 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- УИХ (2016). Төсвийн тухай хууль, УБ
- УИХ (2015). Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УБ
- УИХ (2016). Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ
- УИХ (2016). Хүүхэд хамгааллын тухай хууль, УБ
- УИХ (1999). Гэр бүлийн тухай хууль, УБ
- УИХ (2004, 2016). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, УБ
- НЗД (2007). Хамтарсан багийн дүрэм, УБ
- USAID (2014). *Case management toolkit: A user's guide for strengthening case management services in child welfare* Author (2005). *Child protection policies and procedures toolkit*
- (2014) National Guidance for Child Protection in Scotland.





Хүүхэд хамгааллын тогтолцооны загварыг (хүүхэд хамгааллын хамтарсан багийг) анхан шатны нэгжид (нийслэл, дүүрэг хороонд, орон нутаг сум, багт) бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2,10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9,10-р хороо болон Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл сум, Эрдэнэбулган сумын 4-р багийг сонгон хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2015- 2018 оны хооронд ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжих юм.

#### **Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:**

Үйл ажиллагаа 1: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үйл ажиллагаа 3: Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 4: Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны сургамж, хүрсэн амжилт, үр дүнд үндэслэн холбогдох яамдад нөлөөлөх

#### **Төслөөс хүлээж буй үр дүн:**

- Хамтарсан багийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, зорилтот орон нутаг дахь хүүхдүүдэд хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо зохицуулалтыг хангах механизм бий болж, бэхжиж хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна зорилтот орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломж нэмэгдэнэ.
- Хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүд ба тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын харилцааг сайжруулахад дэмжих, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.
- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн байгууллагуудын зүгээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд ач холбогдол өгч ажиллах нь нэмэгдсэн байна.